

Судалгааны Тойм

№15 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ШҮҮХИЙН ПРАКТИК

ТОВЧ ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЗХШХШТХ” гэх)- ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар хуульд заасан эрх бүхий этгээдийн зүгээс захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээгдсэн. Үүнтэй холбоотойгоор уг зохицуулалтын агуулга, зорилго, шүүхийн практикт хэрэглэж буй байдал, тулгамдсан асуудал зэргийг судлах, хуулийн хэрэгжилтэд гарч буй үр дүн, хүндрэл бэрхшээл зэргийг шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж, нэхэмжлэл, тайлбар зэрэг бодит эх сурвалжид тулгуурлан судлах шаардлага үүссэн юм. Иймээс Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар “Нийтийн

ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүхийн практик” сэдэвт судалгаа хийгдэж, дүгнэлт, зөвлөмж гаргалаа. Энэхүү тоймд судалгааны гол үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг хураангуйлан бэлтгэж, хууль тогтоогч, шүүгч болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа төрийн бус байгууллага, хуульчдад хүргэхийг зорив. Судалгааны дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хаягаас татан авч үзэх боломжтой. Судалгааны тайланг сайжруулахад үнэтэй санал шүүмж өгч, зөвлөж ажилласан МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал болон Нээлттэй Нийгэм Форумын ажилтнуудад талархал илэрхийлье.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, тоон статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, бүлгийн ярилцлагын аргыг голчлон ашиглав. Төрийн бус байгууллагын зүгээс нийтийн ашиг

сонирхлыг төлөөлөн хамгаалахаар захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан захирамж, шүүхийн шийдвэр, тогтоол, магадлал зэрэг баримт бичиг болон захиргааны хэргийн анхан шатны шүүхээс гаргуулан авсан тоон

мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Мөн шүүхэд хандсан төрийн бус байгууллагын төлөөлөлтэй фокус бүлгийн ярилцлага зохион байгуулж,

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тулгарсан асуудлуудын талаар саналыг нь авч, үр дүнг нь судалгаанд ашиглалаа.

СУДАЛГААНЫ ДҮН

Нэг. Төрийн бус байгууллагатай холбоотой дүгнэлт

- ЗХШХШТХ-ийн 18.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж, шүүхэд хандсан төрийн бус байгууллага цөөн байна. Энэ нь нэг талаас төрийн бус байгууллагуудын чадавхтай холбоотой. Нөгөө талаас, шүүх нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдалд ач холбогдол өгөхөөс илүүтэй хуульд заасан хэлбэрийн шаардлагыг гол шалгуур болгож төрийн бус байгууллагын нэхэмжлэл гаргах эрхийг тодорхойлдог, ингэхдээ хуулийн шаардлагыг нэг мөр хэрэглэдэггүйтэй холбоотой.
- ТББ-уудын нэхэмжлэлийн дийлэнх хэсэг нь хүрээлэн буй орчинтой холбоотой, тодруулбал ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцлах талаарх нэхэмжлэл байна. Нийтийн өмч, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд зэрэг хуулиар тогтоосон бусад нийтийн ашиг сонирхол, түүнчлэн байгаль орчныг нөхөн сэргээх зэрэг байгаль орчны бусад асуудлыг хөндсөн нэхэмжлэл цөөн байна.
- Нэхэмжлэлийг шүүхэд хүлээн авах шатанд ТББ-уудад илүү бэрхшээл тулгарч байна. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох хийгээд буцаасан захирамж, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжийн гол үндэслэл нь тухайн төрийн бус байгууллага ЗХШХШТХ-ийн 18.3.1, 18.3.2 дахь заалтад заасан шаардлагыг хангаагүйтэй холбоотой байгаа юм.
- Төрийн бус байгууллагуудын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах эрмэлзэл байвч чадавх нь сул байгаагийн улмаас алдаа дутагдал гарган шүүхээс нэхэмжлэлээ буцаалгах, нэхэмжлэлийг нь хүлээн авахаас татгалзах тохиолдол цөөнгүй гарчээ. Нөгөө талаас, нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангах шаардлагыг нэг нэгээр нь цувуулан тавьж олон удаа буцаах, хариуцагчийн буруу тодорхойлсон үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан зэрэг шүүхийн зүгээс цаашид анхаарахуйц алдаа дутагдал гарсныг дурдах нь зүйтэй.

Хоёр. Шүүхийн шийдвэр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дүгнэлт

- ЗХШХШТХ-ийн 18.3.1, 18.3-т заасан шалгуурыг шүүх харилцан адилгүй байдлаар хэрэглэдэг, тайлбар үндэслэлээ тэр бүр тодорхой бичихгүй байна.
- Шүүх нэг нэхэмжлэлийг өөр өөр үндэслэлээр хэд хэдэн удаа нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоон буцаасан тохиолдол цөөнгүй байв. Энэ нь нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон, буцаасан захирамжид ийнхүү буцаасан шалтгаан, түүнийг хэрхэн арилгаж нэхэмжлэлийг хуульд нийцүүлэх талаар тодорхой дурддаггүйтэй холбоотой.
- Зарим тохиолдолд шүүх төрийн бус байгууллагаас өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж байгааг тайлбарлахыг шаардсан нь үндэслэлгүй юм.
- Шүүхийн шийдвэрт захиргааны байгууллага,

албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхлыг хэрхэн зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй байгаа, Захиргааны ерөнхий хууль болон бусад хуулийн хүрээнд яагаад хууль бус гэж үзсэн, маргааны хүрээнд ямар нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн, түүнийг хэрхэн ойлгож байгаа, тухайн төрийн бус байгууллагын дүрмийн зорилго нь нэхэмжлэлийн агуулгатай нийцэж байгаа эсэх зэргийг тодорхой дурдаагүй байв. Тэрчлэн зарим шийдвэрийн хувьд бүр огт дурдаагүй байгаа нь цаашид нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах төрийн бус байгууллагуудын хувьд нэхэмжлэл, түүний шаардлага, тайлбар, үндэслэлээ илүү сайн боловсруулах, шүүх дээр үр нөлөөтэй мэтгэлцээн өрнүүлэхэд хүндрэл учруулж байна.

- Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор нэхэмжлэл гаргасан төрийн бус байгууллага нь улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдөх зохицуулалттай

ЗӨВЛӨМЖ

Нэг. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр

- Цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлыг голлох шалгуур болгон авч үзэх замаар шүүхэд хандах шалгуурыг хөнгөвчлөх, хялбаршуулах.
- Нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах хүрээг ЗХШХШТХ-иас гадна салбарын бусад хуулиар тодорхойлох нь зүйтэй. Жишээ нь, нийтийн үйлчилгээ, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах асуудлыг салбарын хууль тогтоомжид тусгах боломжтой.

боловч уг хураамжийг төлсөн тохиолдол цөөнгүй байна.

- Захиргааны хэргийн шүүх нь хэргийг бүх талаас нь бүрэн судалж, нотлох баримтыг өөрийн санаачилгаар цуглуулах эрх, үүрэг хүлээдэг боловч судалгаанд хамрагдсан хэргийн хүрээнд уг үүргээ хэрэгжүүлсэн тохиолдол маш цөөн байв.
- Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой ойлголт, хандлага хангалтгүй байна. Шүүхийн шийдвэр гарч хүчин төгөлдөр болсон боловч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нэг жил, эсхүл түүнээс дээш хугацаанд үргэлжилж удааширдаг, эсхүл нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн асуудлаар шүүгч захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх шийдвэр гаргадаг хэдий ч захиргааны байгууллага, албан тушаалтан уг шийдвэрийг үл хүндэтгэдэг тохиолдол ч байгаа нь ажиглагдав.

- Байгаль орчны тухай хууль тогтоомж болон ЗХШХШТХ-ийн 18.3 дахь хэсэгт заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахтай холбоотой зохицуулалтыг нэг мөр болгож уялдуулах нь зүйтэй.
- Төрийн бус байгууллага нь өөрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргаж байгаа боловч нэхэмжлэлийн шаардлага нь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах хүрээнд төрийн байгууллагаас мэдээ, мэдээлэл гаргуулахтай холбоотой тохиолдолд улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөх зохицуулалтыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомжид тусгах шаардлагатай.

- ЗХШХШТХ-ийн 18.3.1, 18.3.2, 52.5.5 дахь заалтад заасан шаардлагыг шүүхүүд харилцан адилгүй байдлаар хэрэглэж байх тул цаашид төрийн бус байгууллагад

хүндрэл бэрхшээл, зайлшгүй бус хязгаарлалт үүсгэхгүй байх үүднээс эдгээр шаардлагыг тогтоох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох хэрэгтэй.

Хоёр. Шүүхээс хуулийг нэг мөр хэрэглэх чиглэлээр

- Шүүхээс хуулийг нэг мөр ойлгох, хэрэглэх хүрээнд ижил тохиолдолд харилцан адилгүй шийдвэр гаргахаас зайлсхийх нь чухал.
- Нэхэмжлэлийг буцаах, хүлээн авахаас татгалзахдаа нэхэмжлэгчийн гаргасан зөрчлийг тодорхойлж, залруулах арга замыг зааж өгөх, нэхэмжлэлд байгаа зөрчлийг нэг удаагийн захирамжаар нэг мөр шийдвэрлэж, хүндрэл чирэгдэл учруулахаас сэргийлэх нь зүйтэй.
- Төрийн бус байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалахаар шүүхэд

хандсан тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн талаар тайлбар, үндэслэл шаардахгүй байх нь зүйтэй.

- Нэхэмжлэгч төрийн бус байгууллага нь ЗХШХШТХ-ийн 18.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан буюу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзсэн үндэслэлийг талууд маргасан эсэхээс үл хамааран шүүхийн шийдвэрт дүгнэж хэвших шаардлагатай.

Гурав. Төрийн бус байгууллагыг чадавхжуулах чиглэлээр

- Шүүхэд нэхэмжлэл гаргахын өмнө бэлтгэл ажлыг сайтар хангах, хуульчтай хамтран ажиллах, ижил төстэй асуудлыг шүүхээс өмнө хэрхэн шийдвэрлэсэн талаар судалгаа хийж нэхэмжлэлээ гаргах.
- ЗХШХШТХ-ийн 18.3 дахь хэсэгт заасан дөрвөн агуулга бүхий нийтийн ашиг сонирхлыг явцуу байдлаар авч үзэхгүйгээр дэлгэрүүлэн ойлгох, олон төрлийн асуудлаар нэхэмжлэл гаргах боломжийг бүрэн ашиглах.
- Төрийн бус байгууллагуудад чиглэсэн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.

- Нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлыг нэхэмжлэлдээ илүү тодорхой тусгах, боломжтой тохиолдолд баримтаар нотлоход анхаарах, нэхэмжлэл гаргахтай холбогдуулан байгууллагын дүрэм болон бусад холбогдох баримт бичгийг бэлтгэх зэргээр зохион байгуулалтаа сайжруулах.

- Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалахтай холбоотойгоор дүрмийн зорилгоо дахин нягталж, шаардлагатай бол дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулж, шүүхэд хандан нэхэмжлэл гаргах боломжоо өргөжүүлж, тогтвортой үйл ажиллагаа явуулах.

СУДАЛГААНЫ БАГИЙН АХЛАГЧ:

Р.Мөнхзул, МХХ-ны Захиргааны эрх зүйн хорооны ҮЗ-ийн гишүүн, Байгаль орчны эрх зүйн дэд хорооны зохицуулагч

СУДЛААЧ:

Д.Баяр, МХХ-ны гишүүн, МУИС-ийн ХЗС-ийн багш
Д.Бадамцэцэг, МХХ-ны гишүүн, Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш
С.Билгүүн, МХХ-ны гишүүн, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн ахлах референт

